



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хоёрдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/166/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХОЁРДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Н.ГЭРЭЛЧУЛУУН
ТАНАА

Дорнод Ц.О.О № 139

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хоёрдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хоёрдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular stamp is placed over the signature. The stamp contains the Mongolian text "АДБОУС-ЫН АУДИТОР" (Auditor of the ADBOUS) and "Т.БАЙГАЛМАА" (T. Baygalmaa) in a circular arrangement around a central emblem. The signature "Т. Байгалмаа" is written in black ink across the stamp.

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>86,434,889.50</u>	<u>96,341,054.07</u>
33	АВЛАГА	00.00	9,424,832.00
335	Бусад авлага	00.00	9,424,832.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	9,424,832.00
35	БАРАА МАТЕРИАЛ	86,434,889.50	86,916,222.07
351	Түүхий эд материал	264,975.10	3,496,898.10
35130	Эм боох материал	264,975.10	3,496,898.10
354	Хангамжийн материал	86,169,914.40	83,419,323.97
35420	Аж ахуйн материал	52,189,691.50	49,439,101.07
35470	Бусад хангамжийн материал	33,980,222.90	33,980,222.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,377,164,288.17</u>	<u>9,230,599,785.66</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,377,164,288.17	9,230,599,785.66
392	Биет хөрөнгө	9,232,556,788.17	9,086,299,785.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,807,299,682.90	8,807,299,682.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-975,516.48	-147,763,844.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	337,343,153.16	320,663,049.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-223,666,283.44	-210,768,046.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	356,721,926.06	367,392,602.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	-82,363,969.53	-95,442,612.61
39217	Ном	38,197,795.50	44,918,954.50
393	Биет бус хөрөнгө	144,607,500.00	144,300,000.00
39301	Програм хангамж	2,087,500.00	2,087,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-680,000.00	-987,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	143,200,000.00	143,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>9,463,599,177.67</u>	<u>9,326,940,839.73</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>9,463,599,177.67</u>	<u>9,326,940,839.73</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>9,463,599,177.67</u>	<u>9,326,940,839.73</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,053,599,483.20	1,053,599,483.20
51101	Өмч: - төрийн	1,053,599,483.20	1,053,599,483.20
512	Хуримтлагдсан үр дүн	8,409,923,095.44	8,273,336,928.50
51210	Өмнөх үеийн үр дүн	8,409,923,095.44	8,409,995,266.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-136,658,337.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	76,599.03	4,428.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>9,463,599,177.67</u>	<u>9,326,940,839.73</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,265,568,244.56	2,323,623,109.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,082,624,544.56	54,021,978.10
120	Нийтлэг татварын бус орлого	9,082,624,544.56	54,021,978.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,082,624,544.56	54,021,978.10
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,082,449,544.56	54,021,978.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	357,009,900.00	440,286,130.91
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,825,933,800.00	1,829,315,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,752,100.00	27,646,630.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	7,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	18,932,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,752,100.00	1,214,630.91
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	351,257,800.00	412,639,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	351,257,800.00	412,639,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,307,270,008.49	2,458,631,629.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,307,270,008.49	2,458,631,629.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,230,557,484.49	2,393,197,141.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,497,990,800.00	1,510,802,668.00
210101	Үндсэн цалин	1,020,264,800.00	1,023,752,315.00
210102	Нэмэгдэл	337,683,078.00	334,673,431.00
210104	Урамшуулал	140,042,922.00	152,376,922.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,228,800.00	199,398,100.00
210201	Тэтгэврийн даатгал	142,309,200.00	146,762,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,979,900.00	13,158,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,983,900.00	10,527,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,996,000.00	2,631,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,959,800.00	26,317,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	308,403,876.00	408,245,207.00
210301	Гэрэл, цахилгаан	6,256,721.00	11,913,529.00
210302	Түлш, халаалт	298,285,403.00	394,112,681.00
210303	Цэвэр, бохир ус	3,861,752.00	2,218,997.00
2104	Хангамж, бараа материалын зардал	137,035,377.20	44,800,344.34
210401	Бичиг хэрэг	8,540,462.00	5,946,239.91
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	4,156,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	885,641.00	894,838.00
210404	Ном, хэвлэл	5,752,100.00	622,036.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270,000.00	462,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	32,718,430.43
2105	Нормативт зардал	5,485,070.00	17,602,718.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,485,070.00	15,067,918.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,534,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,704,002.00	1,023,500.00

Архангай аймгийн Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	2,704,002.00	1,023,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	700,000.00	982,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700,000.00	982,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,857,549.29	210,342,603.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,219,970.00	420,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,637,579.29	209,922,603.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,712,524.00	65,434,488.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,180,100.00	61,040,040.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,912,100.00	57,918,040.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	3,122,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	155.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	155.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,213,924.00	4,394,293.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,213,924.00	4,394,293.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,958,298,236.07	-135,008,520.23
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	138,793,764.66	1,649,817.71
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	138,793,764.66	1,649,817.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145- 225)	-138,793,764.66	-1,649,817.71
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,819,504,471.41	-136,658,337.94

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,053,599,483.20	666,709,418.39	-1,076,214,195.33	644,094,706.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	666,632,819.36	666,632,819.36
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,053,599,483.20	666,709,418.39	-409,581,375.97	1,310,727,525.62
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,819,504,471.41	8,819,504,471.41
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,053,599,483.20	76,599.03	8,409,923,095.44	9,463,599,177.67
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,053,599,483.20	76,599.03	8,409,923,095.44	9,463,599,177.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	72,171.00	72,171.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,053,599,483.20	76,599.03	8,409,995,266.44	9,463,671,348.67
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-72,171.00	00.00	-72,171.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-136,658,337.94	-136,658,337.94
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,053,599,483.20	4,428.03	8,273,336,928.50	9,326,940,839.73

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,183,118,700.00	2,269,601,130.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,182,943,700.00	2,269,601,130.91
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,825,933,800.00	1,829,315,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,752,100.00	27,646,630.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	7,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	18,932,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,752,100.00	1,214,630.91
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	351,257,800.00	412,639,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	351,257,800.00	412,639,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,168,454,820.00	2,255,059,130.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,168,454,820.00	2,255,059,130.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,092,241,796.00	2,189,624,642.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,497,990,800.00	1,520,227,500.00
210101	Үндсэн цалин	1,020,264,800.00	1,033,177,147.00
210102	Нэмэгдэл	337,683,078.00	334,673,431.00
210104	Урамшуулал	140,042,922.00	152,376,922.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,228,800.00	199,398,100.00
210201	Тэтгэврийн даатгал	142,309,200.00	146,762,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,979,900.00	13,158,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,983,900.00	10,527,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,996,000.00	2,631,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,959,800.00	26,317,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	308,403,876.00	408,245,207.00
210301	Гэрэл, цахилгаан	6,256,721.00	11,913,529.00
210302	Түлш, халаалт	298,285,403.00	394,112,681.00
210303	Цэвэр, бохир ус	3,861,752.00	2,218,997.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,772,600.00	13,454,235.91
210401	Бичиг хэрэг	1,766,300.00	2,463,430.91
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	4,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,930,600.00	1,559,465.00
210404	Ном, хэвлэл	6,915,400.00	845,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	770,500.00	1,073,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,389,800.00	3,512,040.00
2105	Нормативт зардал	14,855,300.00	15,123,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,578,000.00	10,277,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,277,300.00	4,845,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,899,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	16,899,000.00	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,704,100.00	1,023,500.00
210702	Дотоод албан томилолт	2,704,100.00	1,023,500.00

Архангай аймгийн Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,715,000.00	9,277,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,915,000.00	8,477,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,672,320.00	16,875,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,672,320.00	16,875,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,213,024.00	65,434,488.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,680,600.00	61,040,040.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,412,600.00	57,918,040.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	3,122,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	155.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	155.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,213,924.00	4,394,293.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,213,924.00	4,394,293.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>14,663,880.00</u>	<u>14,542,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,663,880.00	14,542,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,663,880.00	14,542,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,663,880.00	14,542,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,663,880.00	14,542,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-14,663,880.00</u>	<u>-14,542,000.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,241,954,500.00	2,237,560,052.00	4,394,448.00	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,241,954,500.00	2,237,560,052.00	4,394,448.00	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,181,114,400.00	2,176,720,012.00	4,394,388.00	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,520,227,500.00	1,520,227,500.00	0.00	100
210101	Үндсэн цалин	1,101,909,700.00	1,033,177,147.00	68,732,553.00	93.8
210102	Нэмэгдэл	289,576,100.00	334,673,431.00	-45,097,331.00	116
210104	Урамшуулал	128,741,700.00	152,376,922.00	-23,635,222.00	118
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	199,398,100.00	199,398,100.00	0.00	100
210201	Тэтгэврийн даатгал	146,762,600.00	146,762,600.00	0.00	100
210202	Тэтгэмжийн даатгал	13,158,900.00	13,158,900.00	0.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,527,100.00	10,527,100.00	0.00	100
210204	Ажилгүйдлийн даатгал	2,631,800.00	2,631,800.00	0.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	26,317,700.00	26,317,700.00	0.00	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	412,639,500.00	408,245,207.00	4,394,293.00	98.9
210301	Гэрэл, цахилгаан	11,756,000.00	11,913,529.00	-157,529.00	101
210302	Түлш, халаалт	367,000,000.00	394,112,681.00	-27,112,681.00	107
210303	Цэвэр, бохир ус	33,883,500.00	2,218,997.00	31,664,503.00	6.55
2104	Хангамж, бараа материалын зардал	11,607,700.00	11,607,605.00	95.00	100
210401	Бичиг хэрэг	1,298,800.00	1,298,800.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	4,000,000.00	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,559,500.00	1,559,465.00	35.00	100
210404	Ном, хэвлэл	845,700.00	845,700.00	0.00	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	391,600.00	391,600.00	0.00	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,512,100.00	3,512,040.00	60.00	100

**Архангай аймгийн Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2105	Нормативт зардал	17,873,000.00	17,873,000.00	0.00	100
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,027,400.00	13,027,400.00	0.00	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,845,600.00	4,845,600.00	0.00	100
2107	Томилолт, зочны зардал	1,023,500.00	1,023,500.00	0.00	100
210702	Дотоод албан томилолт	1,023,500.00	1,023,500.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,277,500.00	9,277,500.00	0.00	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,477,500.00	8,477,500.00	0.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9067600.00	9067600.00	0.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,067,600.00	9,067,600.00	0.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60840100.00	60840040.00	60.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,840,100.00	60,840,040.00	60.00	100
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,918,100.00	57,918,040.00	60.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,922,000.00	2,922,000.00	0.00	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,241,954,500.00	2,237,560,052.00	4,394,448.00	99.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,829,315,000.00	1,829,314,845.00	155.00	100
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,829,315,000.00	1,829,314,845.00	155.00	100
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	412,639,500.00	408,245,207.00	4,394,293.00	98.9
132001	Орон нутгийн төсвөөс	412,639,500.00	408,245,207.00	4,394,293.00	98.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	114	127	-13	111
620001	Удирдах ажилтан	01	01	00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	84	88	-04	105
620003	Үйлчлэх ажилтан	29	38	-09	131

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,752,100.00	21,384,030.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,752,100.00	21,384,030.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,752,100.00	21,184,030.91
2104	Хангамж, бараа материалын зардал	5,752,100.00	7,376,030.91
210401	Бичиг хэрэг		1,164,630.91
210404	Ном, хэвлэл	5,752,100.00	5,529,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		682,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		6,000,000.00
210604	Урсгал засвар		6,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	7808000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		7,808,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	200000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		11,792,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		11,792,000.00
223001	Бусад хөрөнгө		11,792,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,752,100.00	33176030.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,752,100.00	33,176,030.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		7,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		18,932,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		6,744,030.91
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хоёрдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа, аудиторын туслах Ц.Аюушжав нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Ж.Ням-Осор, Захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын Хоёр дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймаг Эрдэнэбулган сумын Хоёрдугаар сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хичээл сургалтын үйл ажиллагааг эрүүл аюулгүй байдал, халдвар хамгааллын дэглэмд нийцүүлэн танхимын болон цахим хэлбэрээр тасралтгүй, чанартай зохион явуулж, суралцагчийг сурлагаар хоцрогдох, хичээл завсардахаас сэргийлэн, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, багш өөрийн мэргэжлээр тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хичээл сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөдөлмөрийн сахилга бат, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү аж ахуйн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хяналт шалгалт хийж ажилсан байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хоёр дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, нэмэлт төсвийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Батлагдсан төсөв”-ийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 2,241.9 сая төгрөгийн 1 хувь буюу 22.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хоёрдугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 136.7 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан өөрчлөлт байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	9.4	9.4
Бараа материал	86.4	86.9	0.5
Үндсэн хөрөнгө	9,377.2	9,230.6	-146.6
Нийт хөрөнгө	9,463.6	9,326.9	-136.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,463.6	9,326.9	-136.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,463.6	9,326.9	-136.7

3.5.1. Авлагын үлдэгдэл өмнөх оноос 100 хувиар өссөн байна.

Энэ нь цалин бодохтой холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй ажилтны татварын хөнгөлөлтийг алдаатай бодсоны улмаас татварт илүү төлснөөс үүссэн авлагын үлдэгдэл байна.

3.5.2. Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 0.6 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 86.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 115.8 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн

авсан 3.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд 118.7 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 86.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1.6 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 9,377.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 14.5 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 50.7 сая төгрөг, тус тус нэмэгдэж, 64.5 сая төгрөгийн хөрөнгө акталсан, тайлант хугацааны элэгдэл 209.9 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн акталсантай холбоотойгоор данснаас хассан элэгдэл 62.6 сая төгрөг болж 9,230.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.4. Цэвэр хөрөнгө өмчийн дүн 136.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,825.9	1,829.3	3.4
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	351.3	412.6	61.4
Нэмэлт санхүүжилтийн орлого	5.8	27.6	21.9
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,082.6	50.7	-9,031.9
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		3.3	3.3
Үйл ажиллагааны орлого	11,265.5	2,323.6	-8,942.0
Цалин, шимтгэлийн зардал	1,700.2	1,710.2	10.0
Бараа үйлчилгээний зардал	460.8	471.7	10.9
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.7	1.0	0.3
Бараа үйлчилгээний бусад зардал	68.9	210.3	141.5
Урсгал шилжүүлэг	76.7	65.4	-11.3
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	138.8	1.6	-137.1
Үйл ажиллагааны зардал	2,446.08	2,460.28	14.20
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	8,819.5	-136.7	-8,956.2

Тус сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 61.4 сая төгрөг буюу 17.5 хувиар өссөн нь сургуулийн анги танхим нэмэгдсэнтэй холбоотой санхүүжилт өссөн байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 2,241.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 2,241.9 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,241.9 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,241.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,237.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,237.6 сая төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 27.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2021 онд “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, хичээл сургалтын үйл ажиллагааны явцад халдвараас сэргийлэх дэглэмийг сахиулахтай холбоотой сургууль орчмын бүс, сургалтын байр анги танхимд 2 цаг тутам цэвэрлэгээ, 5 хоногт 1 удаа ариутгал хийж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 91.5 хувь байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан нийт 2,241.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,237.6 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 99.8 хувь байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

Тус сургуулийн бүлэг нэмэгдсэнтэй холбоотой 4 ажилтны орон тоо нэмж томилгоо хийсэн байна.

Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 135 мэдээлэл оруулахаас 128 мэдээлэл хугацаандаа, 7 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах зөрчлүүд илрэв. Үүнд:

1. Тайлангийн жилд тус сургууль нь батлагдсан орон тоог дөрвөөр нэмэгдүүлэн нийт 29.8 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2-д Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх гэснийг хэрэгжүүлээгүй 29.8 сая төгрөгийн зардал гаргасан тул албан шаардлага хүргүүлж байна.

2. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-с доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтын хүрээнд төсвийн хасагдах тохируулга хийснээр тус байгууллага нь 41.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-с доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй 41.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

3. Тус байгууллага нь тогтмол зардалд /гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус/ 78.1 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй ажилсан байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8-д заасан тогтмол зардалд 20-ис доошгүй хувийн хэмнэлт гаргах гэсэн заалтыг мөрдөөгүйд албан шаардлага хүргүүлэв.

4. Багш нарт биеийн тамирын хослол 4.8 сая төгрөгөөр авсан зөрчил гаргаж ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4-д заасан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх гэсэн заалтыг мөрдөөгүйд албан шаардлага хүргүүлэв.

Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1, 1.8, 1.4-д заасан гэсэн заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитаар нийт 17.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн биелэлт бүрэн хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн үйл ажиллагааны үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг хянах.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар нийт 54.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 54.1 сая төгрөгийн алдааг залруулсан, 9.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

4.1 Залруулсан алдаа

- Цалингийн өглөг дансны бүртгэлийг 31.8 сая төгрөгөөр зөрүүтэй, алдаатай бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 31.8 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тухай 2022 оны 2 дугаар сарын 25-ний өдрийн № 27 албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

- Санхүүгийн тайлангийн уялдаа 0.2 сая төгрөгөөр алдаатай байсан нь ном актлахдаа ном хэвлэлийн зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар" тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 0.2 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тухай 2022 оны 2 дугаар сарын 25-ний өдрийн № 27 албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

- НДШ-ын зардлаас тооцоо дансаар дшууд төлөлт хийсэн 14.7 сая төгрөгний алдаа гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар" тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 14.7 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тухай 2022 оны 2 дугаар сарын 25-ний өдрийн № 27 албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

- Түрээсийн номын төлбөр 5.5 сая төгрөгийг зардалд бүртгэсэн

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар" тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 5.5 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тухай 2022 оны 2 дугаар сарын 25-ний өдрийн № 27 албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

- Хүнсний материалын 1.9 сая төгрөгийн зарцуулалтыг анхан шатны баримтаарх зарцуулалтын дүнгээс зөрүүтэй бүртгэгдсэн

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар" тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 1.9 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тухай 2022 оны 2 дугаар сарын 25-ний өдрийн № 27 албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Зөвлөмж

- Цалин бодохдоо холбоотойгоор групптэй болон татварын хөнгөлөлтийн алдаатай бодолтын улмаас үүссэн татварт илүү төлсөн авлага үүнийг ажилчдад төлөх өглөгөөр бүртгэж барагдуулах

Шийдвэрлэсэн нь: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-тай нийцэхгүй байгаа тул залруулах зөвлөмж хүргүүлэв.

Залруулсан зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Ерөнхий боловсролын Хоёр дугаар сургууль	6	63.5	5	54.1	0	0	0	0	1	9.4
Дүн		6	63.5	5	54.1	0	0	0	0	1	9.4
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Ерөнхий боловсролын Хоёр дугаар сургууль	5	154.5	0	0	0	0	5	154.5	0	0
Дүн		5	154.5	0	0	0	0	5	154.5	0	0
Нийт дүн		11	218.0	5	54.1	0	0	3	154.5	1	9.4